

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН 2020 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД
ОРОЛЦСОН НЭР ДЭВШИГЧДИЙН
СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: /ӨВА-2020/04/-НА/

Арвайхээр хот
2020 он

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга бөгөөд Тэргүүлэх аудитор О.Батжаргал
Утас: 70323253, цахим хаяг:

Аудитын менежер Д.Гансүх, Утас: 70323833,
цахим хаяг: Gansukhd@audit.gov.mn

Ахлах аудитор: П.Хорлоосүрэн, Утас: 70323108,
цахим хаяг: Khorloosuren@audit.gov.mn

Аудитор: Ө.Ринчинмядаг, Утас: 70323108,
цахим хаяг: Renchinmyadagu@audit.gov.mn

Аудитор: Э.Энхбаяр, Утас: 70323108,
цахим хаяг: Enkhbayare@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой
нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Аудитын нэр

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслээс болон бие даан нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлан баталгаажуулах.

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д “Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ.” гэж заасныг үндэслэн аймгийн аудитын газар нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланг хянаж баталгаажуулсан.

Аудитын зорилго

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслээс болон бие даан нэр дэвшигчдийн төвлөрүүлсэн орлого, иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив, сонгуулийн зардлыг хянаж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, нийтэд мэдээлнэ.

Аудитын хамрах хүрээ

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслээс болон бие дааж нэр дэвшигчдийн аудитын дүгнэлт, аудитын дэлгэрэнгүй тайлан, аудит хийгдсэн сонгуулийн зардлын тайлангийн маягтууд, харилцагч банкны дансны хуулга бусад шаардлагатай баримтуудыг хамарсан.

Арга зүй

Аудитын ажлыг гүйцэтгэхэд Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудиторын 2020 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/16 тоот тушаалаар баталсан “Сонгуулийн зардлыг тайлагнах заавар, журмыг”-ыг үндэслэн нэр дэвшигчдийн өөрийн хөрөнгө, нам, эвслээс оруулсан хөрөнгө, иргэн, хуулийн этгээдээс авсан хандив түүний зарцуулалтын тайланг шалгаж, аудит хийсэн хуулийн этгээд, нам, эвсэл, нэр дэвшигчдээс лавлагаа, тодруулга авч, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж тайланг бэлтгэв.

Үндсэн мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн 39 тойротг 4 намаас 977 нэр дэвшигч сонгуульд оролцсон байна. Үүнд:

- Монгол Ардын нам 488
- Арчилсан нам 483
- Монгол Ардын хувьсгалт нам 5
- Үнэн ба зэв нам 1

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчдээс сонгуулийн зардлын тайлангаа ирүүлсэн 688 нэр дэвшигчдийн дансанд нийт 274.4

сая төгрөгийн орлого төвлөрч, сонгуулийн үйл ажиллагааны зардалд 267.9 сая төгрөг зарцуулж, харилцах дансанд 174 нэр дэвшигчийн дансанд 6.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Сонгуульд нэр дэвшигчдэд 9 хуулийн этгээд 10.1 сая төгрөг, 738 иргэн 194.5 сая төгрөгийн мөнгөн хандив, 2 хуулийн этгээд 0.4 сая төгрөг, 7 иргэн 1.1 сая төгрөгийн мөнгөн бус хандив өгсөн байна.

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудиторын 2020 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн А/09 дугаар тушаалаар Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд аймгийн нэр дэвшигчдийн зарцуулах зардлын дээд хэмжээг тухайн тойргоос хамааран 8.8-43.4 сая төгрөгөөр, сумын нэр дэвшигчдийн зарцуулах зардлын дээд хэмжээг 1.8-18.9 сая төгрөгийн хооронд тогтоосон зардлын дээд хэмжээг хэтрүүлсэн нэр дэвшигч байхгүй байна.

Сонгуулийн зардлын дансны орлого, зарлага

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-д “Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.” гэж заасны дагуу сонгуулийн зардлын тайлангаа 977 нэр дэвшигчээс 709 нэр дэвшигч хугацаандаа ирүүлсэн 268 нэр дэвшигч тайлангаа ирүүлээгүй байна. Үүнд:

- Монгол Ардын Нам 1
- Ардчилсан нам 264
- Монгол Ардын хувьсгалт нам 2
- Үнэн ба зөв нам 1

Бат-Өлзий сумын Монгол Ардын Намаас нэр дэвшигч болон Өлзийт, Бүрд, Төгрөг, Сант, Есөнзүйл, Хайрхандулаан сумдын Ардчилсан намаас нэр дэвшигчид зардлын тайлангаа ирүүлээгүй байна. /Нэрсийг тайланд хавсаргав/

Нийт 709 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангаа ирүүлж аудитын хуулийн этгээдээр баталгаажуулсан байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3-д “Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй.” гэж заасны дагуу дансны дугаар, банкны нэрийг бүртгүүлсэн 943 нэр дэвшигч, бүртгүүлээгүй 34 нэр дэвшигч байна.

Нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлангаарх нийт орлого 275.9 сая төгрөгийн 274.4 сая төгрөг нь мөнгөн, 1.5 сая төгрөг нь мөнгөн бус хандив байна. Мөнгөн хандивын орлогыг хавсралт 1-ээр харуулсан. Нийт орлогыг дараах байдлаар харуулав. Үүнд:

Хүснэгт-1 Нэр дэвшигчдийн орлого /сая.төгрөг/

Орлогын төрөл	Орлого				Нийт	
	Тоо	Мөнгөн	Тоо	Мөнгөн бус	Тоо	Дүн
Нам, эвслээс оруулсан мөнгөн хөрөнгө	-	-	-	-	-	-
Нэр дэвшигчдийн өөрийн хөрөнгө	128	69.8	-	-	128	69.8
Хуулийн этгээдийн хандив	9	10.1	2	0.4	11	10.5
Иргэний хандив	738	194.5	7	1.1	745	195.6
Дүн	875	274.4	9	1.5	884	275.9

Нэр дэвшигчид сонгуулийн үйл ажиллагааны зардалд нийт 267.9 сая төгрөг зарцуулснаас сонгуулийн зардалд 265.2 сая, бусад зардалд 2.7 сая төгрөг зарцуулжээ. Үүнд:

Хүснэгт-1 Нэр дэвшигчдийн зардал /сая.төгрөг/

Зардлын ангилал			Мөнгөн дүн
Нийт зардлын дүн			267.9
2.1	Сонгуулийн зардлын дүн		265.2
	2.1.1	Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах	42.7
	2.1.2	Нийтийн эзэмшлийн гудамж талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах	1.7
	2.1.3	намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал	
	2.1.4	сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал	4.2
	2.1.5	сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал	204.4
	2.1.6	сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардал	9.6
	2.1.7	цахим орчин ашиглах зардал	1.9
	2.1.8	өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал	0.7
2.2.	Бусад зардлын дүн		2.7

Нэр дэвшигчдийн сонгуулийн зардалтай холбоотой төлөгдөөгүй байгаа өр төлбөр байхгүй байна.

Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандив:

Хандив өгч байгаа иргэн, хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээлэл дутуу, буцах хаяг тодорхойгүй зэрэг шалтгаантай дараах хандивуудыг буцаасан байна. Үүнд:

- Монгол Ардын намаас 5 сумын 21 сонгуульд нэр дэвшигч, аймгийн ИТХ-ын сонгуульд оролцогч 14 нэр дэвшигчээс нийт 22.2 сая төгрөгийн хандивыг буцаасан байна.
- Ардчилсан намаас 2 сумын 2 сонгуульд нэр дэвшигч, аймгийн ИТХ-ын сонгуульд оролцогч 5 нэр дэвшигчээс 2.3 сая төгрөгийн хандивыг буцаасан байна.

Сонгуулийн зардлын тайланда хийсэн аудитын илрүүлэлт:

Аудитын хуулийн этгээд нь Аймгийн тэргүүлэх аудиторын 2020 оны 10 дугаар сарын 16-ний өдрийн А/16 дугаар тушаалаар баталсан "Сонгуулийн зардлыг тайлاغнах заавар, журам"-ын дагуу аудит хийж, сонгуулийн зардлын тайлангийн аудитаар нийт 4.2 сая төгрөгийн санхүүгийн анхан шатны баримт хангальгүй зөрчил илэрсэн байна.

Аудитын дүгнэлт

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нам, эвслээс нэр дэвшигчдийн аудитын хуулийн этгээдээр баталгаажуулсан 709 нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг үнэн зөв, иж бүрэн илэрхийлэгдсэн гэж дүгнэлт гарсан байна.

Зөвлөмж: Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэн Ч.Болормаад:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй нэр дэвшигчдэд Зөрчлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дүгээр зүйлд заасны дагуу хариуцлага тооцуулах.

Монгол Ардын намаас нэр дэвшигч нарт нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг жагсаалт

№	Сумын нэр	Нэр дэвшигчийн нэр	Хандивлагч			Хандивын эх үүсвэр	Хандивласан огноо		
			Иргэн						
			Нэр	Регистрийн дугаар	Хандивын хэмжээ/төгрөг/				
1	Аймгийн ИТХурал	Т.Нарангараав	С.Түмэнжаргал	йю86090877	2,000,000	цалин	2020.09.29		
2	Аймгийн ИТХурал	Д.Азбилэг	Д.Мөнхжаргал	йм91052614	2,000,000	цалин	2020.10.01		
3	Аймгийн ИТХурал	Д.Азбилэг	Д.Төмөрбат	йс76050734	2,000,000	цалин	2020.10.02		
4	Аймгийн ИТХурал	Т.Дашням	Д.Ганхулэг	йо55050614	2,000,000	тэтгэвэр	2020.09.29		
5	Аймгийн ИТХурал	Д.Лхаморолмаа	Д.Буянтогтох	йс85010819	2,000,000	цалин	2020.10.09		
6	Аймгийн ИТХурал	О.Батжаргал	А.Эрдэнэтунгалааг	йс69070809	2,000,000	цалин	2020.09.28		
7	Аймгийн ИТХурал	О.Батжаргал	Б.Таванжин	йс72041305	2,000,000	цалин	2020.10.06		
8	Аймгийн ИТХурал	Г.Алтангэрэл	Г.Батэрдэнэ	иж77050516	2,000,000	бизнесийн орлого	2020.10.07		
9	Аймгийн ИТХурал	Г.Алтангэрэл	Г.Авидгэрэл	иж84100115	2,000,000	бизнесийн орлого	2020.10.07		
10	Аймгийн ИТХурал	М.Батзориг	Багахүү	йю93071111	2,000,000	цалин	2020.10.07		
11	Аймгийн ИТХурал	М.Батзориг	Б.Цэрэндуулам	йю62100705	2,000,000	бизнесийн орлого	2020.10.07		
12	Аймгийн ИТХурал	А.Ишдорж	Р.Нарантуяа	йй81091409	1,900,000	цалин	2020.10.02		
13	Аймгийн ИТХурал	Б.Ганбат	Б.Ганзориг	йв84012118	1,900,000	бизнесийн орлого	2020.10.07		
14	Аймгийн ИТХурал	Д.Амартувшин	Д.Мөнхзул	йр89030603	1,900,000	бизнесийн орлого	2020.10.13		
15	Аймгийн ИТХурал	О.Пүрэвдорж	О.Эрдэнэцэцэг	йю79060802	1,800,000	цалин	2020.10.07		
16	Аймгийн ИТХурал	М.Батзориг	Цэдэндолгор	йю78102265	1,500,000	бизнесийн орлого	2020.10.07		
17	Аймгийн ИТХурал	М.Батзориг	П.Батзориг	вг84032218	1,500,000	бизнесийн орлого	2020.10.12		
18	Аймгийн ИТХурал	Г.Дашжанцан	Л.Жавзмаа	йе82010407	1,350,000	хуритлал	2020.10.09		
19	Аймгийн ИТХурал	Д.Эрдэнэсүрэн	Ч.Гомбосүрэн	йм79030413	1,320,000	маа орлого	2020.10.09		
20	Аймгийн ИТХурал	Д.Түмэнөлзий	Б.Мянганбаяр	ий74020703	1,001,000	цалин	2020.10.08		
21	Аймгийн ИТХурал	Г.Дашжанцан	Б.Буянтогтох	ОД81071512	1,000,000	Цалин	2020.09.30		
22	Аймгийн ИТХурал	Т.Нарангараав	Н.Дуламсүрэн	йб33040504	1,000,000	тэтгэвэр	2020.09.30		
23	Аймгийн ИТХурал	Т.Батөлзий	Д.Төмөрдөш	йз58100818	1,000,000	маа орлого	2020.10.13		
24	Аймгийн ИТХурал	С.Үндрэх	Ц.Цогтбаяр	уз70020510	1,000,000	бизнесийн орлого	2021.10.01		
25	Аймгийн ИТХурал	Б.Уганбаяр	О.Пүрэвдаш	чм48071411	1,000,000	цалин	2020.10.05		
26	Аймгийн ИТХурал	Д.Бямбадорж	Д.Нарангараал	йд78010101	1,000,000	бизнесийн орлого	2020.10.02		
27	Аймгийн ИТХурал	Т.Дашням	Б.Цэцэгсайхан	йю55012860	1,000,000	тэтгэвэр	2020.10.09		
28	Аймгийн ИТХурал	И.Доржсүрэн	Ш.Баяrbat	йр87052675	1,000,000	цалин	2020.09.30		
29	Аймгийн ИТХурал	И.Доржсүрэн	Ж.Амарбаясгалан	йю86102611	1,000,000	бизнесийн орлого	2020.10.13		
30	Аймгийн ИТХурал	Г.Одгэрэл	М.Номуундарь	йр82102500	1,000,000	цалин	2020.10.13		
31	Аймгийн ИТХурал	Д.Энхзаяа	Ч.Нармандах	йр70102101	1,000,000	бизнесийн орлого	2020.10.06		
32	Аймгийн ИТХурал	Д.Лхаморолмаа	Б.Лхвгасүрэн	йю87102036	1,000,000	цалин	2020.10.09		

№	Сумын нэр	Нэр дэвшигчийн нэр	Хандивлагч			Хандивын эх үүсвэр	Хандивласан огноо		
			Хуулийн этгээд						
			Нэр	Регистрийн дугаар	Хандивын хэмжээ/төгрөг/				
1	Аймгийн ИТХурал	Б.Батмөнх	Арвай Илч XXX	3550133	3,000,000	Бизнесийн орлого	2020.09.24		
2	Аймгийн ИТХурал	Д.Баянмөнх	Террамед XXX	6190758	3,000,000	Бизнесийн орлого	2020.10.01		
Нийт дун					6,000,000				

Ардчилсан намаас нэр дэвшигч нарт нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг жагсаалт

№	Сумын нэр	Нэр дэвшигчийн нэр	Хандивлагч			Хандивын Эх үүсвэр	Хандивласан огноо		
			Иргэн						
			Нэр	Регистрийн дугаар	Хандивын хэмжээ/төгрөг/				
1	Уянга	Т.Болдбаатар	Т.Адъяадулам	ЙО35012021	1,000,000	Тэтгэвэр	2020.10.01		
2	Хархорин	Л.Энхбат	З.Мэндсайхан	ЧЖК52071414	1,000,000	цалин	2020.10.08		
3	Арвайхээр	С.Отгон	О.Адъяасурэн	ЙЮ85063030	1,000,000	Бизнесийн орлого	2020.10.06		
4	Баян-Өндөр	С.Чулуунпүрэв	Б.Саруул	ХМ86121171	1,000,000	цалин	2020.10.07		
Нийт дун					4,000,000				

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

6217143681
ИЮ40059 9044094